МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ: СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИРХИЙЛЭЛ”

Судалгааны төрөл:	**Хамаарлын судалгаа**
Судалгааны код:	**БГСТ-24/053**
Хугацаа:	**2025.12.09-2025.12.23**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: А.Эрхэс, МА

Улаанбаатар хот
2024 он

Товчилсон үгийн жагсаалт

НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
CTS	Conflict Tactics Scale
DASS-21	Depression Anxiety stress scale
EAC	Emotional Abuse Checklist
RMSEA	Root Mean Square Error of Approximation

Гадаад нэр томьёоны тайлбар

Behaviorally-Based Screening Tools Хүний зан төлөвт үндэслэн тодорхой асуудал, ялангуяа хүчирхийлэл болон сэтгэл зүйн асуудлуудыг үнэлэхэд ашигладаг хэмжүүрийн хэрэгсэл. Энэ нь бие даасан зан үйлийн үндсэн дээр дүгнэлт гаргах зорилготой.

Conflict Tactics Scale (CTS) Хүчирхийлэл, зөрчлийг үнэлэхэд зориулсан аргачлал. Энэ нь гэр бүлийн болон харилцааны хүчирхийллийн төрөл, давтамжийг хэмжихэд ашиглагддаг.

Depression Anxiety Stress Scale (DASS) Сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн түвшнийг үнэлэхэд ашиглагддаг сэтгэл зүйн хэмжүүр. Үүнд богино (21 асуулттай) болон урт (42 асуулттай) хувилбарууд багтдаг.

Emotional Abuse Checklist (EAC) Сэтгэл зүйн хүчирхийллийг үнэлэхэд ашигладаг жагсаалт. Энэ нь тухайн хүний сэтгэл санааны байдалд үзүүлэх дарамт, хүчирхийллийн хэлбэрүүдийг тодорхойлоход тусалдаг.

Root Mean Square Error of Approximation (RMSEA) Загварын тохироцийн үнэлгээний үзүүлэлт. Энэ нь статистикийн загвар өгөгдөлд хэр нийцэж буйг хэмждэг бөгөөд бага байх тусам загварын нийцэмж сайн байна гэж үздэг.

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгт 1. DASS-21 Боловсруулах хүснэгт 18
Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлийн төрөл ба асаргаа шаардлагатай эсэх 27
Хүснэгт 3. Хүчирхийллийн асуумжийн дундаж оноо 27
Хүснэгт 4. Өөрийн үнэлгээнээс шалтгаалж хүчирхийллийн тестийн оноо 27
Хүснэгт 5. Хүйсээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал ялгаатай эсэхэд шинжилгээ хийсэн үр дүн 28
Хүснэгт 6. Нас болон хүчирхийллийн харилцан хамаарал 28
Хүснэгт 7. Нас нь хүчирхийлэлд өртөхөд хэрхэн нөлөөлж буйг шалгасан үр дүн 29
Хүснэгт 8. Боловсролын түвшин ба бусад ерөнхий мэдээллийн хамаарал 30
Хүснэгт 9. Хүүхэдтэй эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал 32
Хүснэгт 10. Сэтгэл зүйн асуудлууд болон хүчирхийллийн хамаарал 34
Хүснэгт 11. Хүчирхийллийн түгшүүрийн түвшинд үзүүлэх нөлөө 35
Хүснэгт 12. Хүчирхийллийн стрессийн түвшинд үзүүлэх нөлөө 35
Хүснэгт 13. Хүчирхийллийн сэтгэл гутралын түвшинд үзүүлэх нөлөө 36

График 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа 25
График 2. Боловсролын түвшин 26
График 3. Судалгаанд оролцогчдын нийгмийн идэвх /Өөрийн үнэлгээ/ 26
График 4. Боловсролын түвшнээс шалтгаалан хүчирхийлэлд өртсөн байдал ялгаатай эсэхийг шинжилсэн үр дүн 29
График 5. Хүчирхийллийн тухай ерөнхий ойлголтоос шалтгаалан хүчирхийлэлд өртөх байдал ялгаа 31
График 6. Асаргаа шаардлагатай эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдлын ялгаа 32
График 7. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй түвшний ялгаа 33
График 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн асуудал 33
График 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн асуудал 34

Хавсралт 1. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээллийн асуулга 41
Хавсралт 2. EAC хүчирхийллийг тодорхойлох асуумж 42
Хавсралт 3. DASS-21 (Depression Anxiety Stress Scale) буюу сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хэмжүүрийн тест 43

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт i

Гадаад нэр томьёоны тайлбар ii

Хүснэгт, графикийн жагсаалт iii

УДИРТГАЛ 1

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ 3

1.1. Хөгжлийн бэрхшээлийн тухай ерөнхий ойлголт 3

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай холбогдох хууль тогтоомж болон онолын ойлголтууд 4

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ 10

2.1. Хүчирхийллийн эсрэг хууль, эрх зүйн орчин 10

2.2. Хүчирхийллийн хэлбэрүүд болон сэтгэл зүйн хүчирхийлэл 12

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИОЛДОЖ БУЙ СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙ 15

3.1. Сэтгэл зүйн хүчирхийллийг тодорхойлох аргачлал 15

3.1.1. Ярилцлагын арга 15

3.1.2. Хүчирхийллийг тодорхойлох ЕАС асуумж (Henry, 2013) 15

3.2. Сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх аргачлал 18

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИОЛДОЖ БУЙ СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН 20

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн тохиолдол 20

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн хүчирхийллийг судалсан үр дүн 25

4.3. Хөгжлийн бэршээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн зарим асуудлууд 33

ДҮГНЭЛТ 37

ЗӨВЛӨМЖ 38

НОМ ЗҮЙ 39

ХАВСРАЛТ 41

УДИРТГАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах асуудал нь нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангах хамгийн чухал талуудын нэг юм. Олон улсын байгууллагууд, тухайлбал НҮБ болон ДЭМБ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах талаар олон удаа зөвлөмж гаргаж, энэ бүлгийн хүмүүсийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг шаардсан байдаг (UN, 2006). Монгол Улсад ч энэ асуудалтай холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” 2016 онд батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хамгаалалт шинэ шатанд гарсан боловч хэрэгжилт нь тодорхойгүй, хэрэгжилтийн байдлыг үнэлэх шаардлагатай байна (Төрийн мэдээлэл, 2016).

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дэлхийн нийт хүн амын ойролцоогоор 15 хувийг эзэлдэг бөгөөд тэдний олонх нь нийгмийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчилд өртсөөр байна (World Health Organization, 2011). Сэтгэл зүйн хүчирхийлэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хамгийн түгээмэл, боловч үл анзаарагддаг хүчирхийллийн хэлбэрүүдийн нэг юм. Энэ нь тэдний сэтгэл санаанд ноцтой хор уршиг учруулж, нийгмийн харилцаанд оролцох, өөртөө итгэх итгэл, амьдралын чанар зэрэгт сөргөөр нөлөөлдөг (Mikton & Butchart, 2009).

Сэтгэл зүйн хүчирхийлэл нь ганцаардах, өөрийгөө үнэ цэнгүй гэж үзэх, сэтгэл гутралд өртөх, амиа хорлох бодол төрөх зэрэг сэтгэл зүйн сөрөг байдлуудын эрсдэл нэмэгдүүлдэг тул хүчирхийлэлд өртсөн хүмүүс нийгмийн амьдралаас холдож, өөрийгөө тусгаарлах хандлагатай болгож улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох, ажиллах, өөрийгөө хөгжүүлэх боломжийг хязгаарлахад хүргэдэг.

Сэтгэл зүйн хүчирхийлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд гүн нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь эдийн засгийн, бие махбодын хүчирхийлэлтэй адилхан хор уршигтай (Simeonsson, R. J., et al, 2011). Өнөөдөр сэтгэл зүйн хүчирхийллийн талаар дэлхий даяар олон судалгаа хийгдэж, энэ төрлийн хүчирхийлэл нь тухайн хүний сэтгэл зүй, сэтгэхүйн болон нийгмийн харилцааг урт хугацаанд сүйтгэдэг гэдгийг нотолсон (Waldman, 2014). Монгол улсад энэ асуудал дунд сургуулийн болон их дээд сургуулиуд, мөн бусад нийгмийн байгууллагуудаар хязгаарлагдмал хэмжээнд судлагдсан бөгөөд олон нийтэд нээлтэй мэдээлэл дутмаг байна.

Тиймээс энэ судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн хамгаалалт болон тэдэнд тулгарч буй сэтгэл зүйн хүчирхийллийн асуудлыг судалж үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Судалгааны зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн хүчирхийллийг тодорхойлох.

Судалгааны зорилт:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудал, хүчирхийллийн тухай хууль эрх зүйн орчин болон онолын түвшинд судалж дүгнэлт гаргах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн хүчирхийллийг тодорхойлох судалгааны арга зүйг сонгож, зорилтод түүврээс судалгааг авах;
3. Судалгааны үр дүнд боловсруулалт хийж дүгнэлт, зөвлөмж гаргах.

Судалгааны таамаглал: Судалгаанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн бөгөөд энэ нь сэтгэл зүйн хор хохирол учруулдаг.

Судалгааны ач холбогдол:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахын тулд сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй эсэхийг тодорхойлох;
2. Судалгааны үр дүнд тулгуурлан бодлого боловсруулагчид, нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид илүү үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалснаар тэдний амьдралын чанарыг сайжруулж, нийгэмд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Судалгааны шинэлэг тал: Өнөөгийн судалгааны олонх нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие махбодын хүчирхийлэлд, эсвэл хүндэрсэн нөхцөлд тусгай үйлчилгээ авах боломжгүй байдалд төвлөрдөг. Харин энэ судалгаа нь сэтгэл зүйн хүчирхийллийн хэлбэрийг илрүүлж, тус асуудлын үнэлгээг нарийвчлан хийснээрээ давуу талтай.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

1.1. Хөгжлийн бэрхшээлийн тухай ерөнхий ойлголт

Хөгжлийн бэрхшээл нь хүн амын тодорхой хэсгийн биологийн, сэтгэл зүйн эсвэл нийгмийн чадавхуудын хязгаарлалт юм. Энэ нь тухайн хүн өөрийн орчинд амьдрах, суралцах, ажиллах, нийгэмд оролцох, хүлээн авах үүрэг гүйцэтгэх боломжийг хязгаарладаг. Хөгжлийн бэрхшээл нь зөвхөн бие махбодын эмгэгээс гадна сэтгэл зүйн болон нийгмийн хүчин зүйлсээр ч тодорхойлогдож болох юм (World Health Organization, 2011).

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай ойлголт нь олон улсын стандартууд болон тухайн улсын эрх зүйн хүрээнд өөр өөр байж болох ч үндсэндээ хоёр том бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг:

1. Биологийн хүчин зүйлс - Бие махбодын хомсдол, өвчин эсвэл гэмтэл.
2. Нийгмийн хүчин зүйлс - Орчны хязгаарлалт, нийгмийн халамж, боловсролын болон эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, нийгэмд бүрэн оролцоогүй байх байдал (Shakespeare, 2006).

Хөгжлийн бэрхшээл нь олон төрөлтэй бөгөөд тэдгээр нь дараах үндсэн бүлгүүдэд хуваагддаг:

1. Бие махбодын хөгжлийн бэрхшээл: Энэ нь хөдөлгөөний чадвар, амьсгалын эсвэл мэдрэлийн тогтолцооны хязгаарлалттай холбоотой байдаг. Жишээ нь, саажилт, даралттай өвчнүүд, үүдэл эсийн эмгэгүүд гэх мэт.
2. Сэтгэл зүйн хөгжлийн бэрхшээл: Энэ нь оюун санааны хөгжлийн алдагдлаас үүдэлтэй байдаг бөгөөд аутизм, оюуны хомсдол, сэтгэцийн эмгэгүүдийг агуулдаг.
3. Сонсголын бэрхшээл: Сонсголын бүрэн эсвэл хэсэгчилсэн алдагдал, чихний бүтцийн өөрчлөлтүүдээс үүдэлтэй.
4. Харааны бэрхшээл: Нүдний хараа муудах буюу бүрэн хараагүй байх зэрэг.
5. Нийгмийн хөгжлийн бэрхшээл: Нийгмийн харилцааны болон нийгэмд оролцооны хязгаарлалтуудыг агуулдаг (WHO, 2011).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, нийгэмд хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг нь нийгмийн ялгаварлан гадуурхалтыг дагуулдаг. Тэдгээрийг олон нийтийн үйлчилгээ, боловсрол, ажил эрхлэлт болон бусад нийгмийн амьдралд

хязгаарлалтуудтай тулгардаг (Oliver M. , 1996). Сэтгэл зүйн хүчирхийлэл, гадуурхалт зэрэг асуудлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрсдэл учруулж, тэдний нийгэмд оролцох боломжийг улам бүр бууруулдаг. Үүнээс гадна эдгээр хүн амын бүлгүүдийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн хамгааллын системд хүртээмжтэй байдлын асуудал мөн чухал юм.

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай холбогдох хууль тогтоомж болон онолын ойлголтууд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь хүмүүнлэгийн бүх үндсэн эрхүүдтэй нийцэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн эрхийг хамгаалах тухай хууль, тогтоомж, олон улсын гэрээ нь хүмүүсийн тэгш эрх, аз жаргалтай амьдрах эрхийг баталгаажуулахад чиглэсэн байдаг. 2006 онд батлагдсан НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь энэ асуудлыг дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн гол баримт бичиг юм. Энэ конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх, тэдний хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үндсэн чиглэлээр ажиллахыг шаарддаг (UN, 2006).

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдний амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр хэд хэдэн хууль, тогтоомжуудыг баталсан байдаг. Эдгээр хуулиуд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандарттай нийцэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш эрхтэй байх, тэдний нийгэмд оролцох боломжийг хангах зорилгоор боловсруулагдсан юм.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль (2016)[1]

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах гол хууль бөгөөд 2016 оны 4 дүгээр сарын 28-нд батлагдсан. Энэ хуулийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг тэгш хамгаалах, тэдэнд зориулсан бүх төрлийн үйлчилгээ, нөхцөлийг хангуулах явдал юм.

Тэгш боломж олгох: Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, эдийн засагт оролцох, боловсрол эзэмших, ажил эрхлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах зэрэг тэгш эрхтэй байх үүрэг хүлээлгэн, нийгмийн хөгжлийн талаар тодорхой бодлого баримтлахыг зааж өгчээ.

[1] https://legalinfo.mn/mn/detail/11711

Бодлого боловсруулах: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бодлого боловсруулах, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсрол, хөдөлмөрийн нөхцөл зэрэгт тэдний оролцоог дэмжихийг зөвшөөрдөг.

2. Монгол Улсын Үндсэн хууль (1992)[2]

Монгол Улсын Үндсэн хууль нь бүх иргэдийн тэгш эрхийг хамгаалах үндсэн баримт бичиг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч мөн тэгш эрх олгохыг баталгаажуулдаг. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд "Хүний эрх, эрх чөлөөний хамгаалалт" гэж заасан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах үндсэн хуульч үзэл санаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хамгаалалт нь Үндсэн хуульд тусгагдсан "тэгш байдал", "ил тод байдал", "ерөнхий тусламж үйлчилгээ" гэсэн зарчмуудтай нийцдэг байна.

3. Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль (2011)[3]

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээг хангах, эрүүл мэндийн үйлчилгээний нөхцөлийг дэмжихээр зохицуулсан байдаг. 2011 оны хуулийн шинэчилсэн найруулга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад тэгш эрхтэй байхыг заасан.

4. Хөдөлмөрийн тухай хууль (2021)[4]

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль нь хөдөлмөр эрхлэлтийн тэгш эрхийг хамгаалах үндсэн хууль бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэд хэдэн заалтуудтай. Тус хуульд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх, ажилд оролцох, ажиллах нөхцөлийг хангах" заалтуудыг тусгажээ. Үүнээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх талаар тусгасан.

5. Нийгмийн халамжийн тухай хууль (2012)[5]

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг халамж үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохицуулалттай байдаг. Энэ

[2] https://legalinfo.mn/mn/detail/367
[3] https://legalinfo.mn/mn/detail/49
[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751
[5] https://legalinfo.mn/mn/detail/393

хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбох, эдийн засгийн тусламж үзүүлэх, амьжиргааны түвшнийг сайжруулах зорилгоор тодорхой тэтгэмжүүдийг олгох нөхцөлүүдийг баталжээ.

Олон улсын гэрээ, конвенцууд:

1. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006)

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэднийг ялгаварлан гадуурхахгүй байх, нийгэмд тэгш оролцох боломжийг бий болгох зорилгоор батлагдсан[6]. Энэ конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах дэлхий нийтийн хуулийн гол баримт бичиг юм. Конвенцийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хүндэтгэх, тэднийг нийгэмд бүрэн оролцуулах, орон сууц, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад олон салбарт тэгш боломж олгох талаар тодорхой үүрэг хүлээлгэдэг.

2. НҮБ-ын Хүний эрхийн тунхаглал (1948)[7]

НҮБ-ын Хүний эрхийн тунхаглал нь бүх хүмүүсийн эрхийг тэгш хамгаалах үндсэн баримт бичиг бөгөөд бүх улсын хууль тогтоомж, үйл ажиллагааг чиглүүлдэг. Энэ тунхаглал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг ч хамгаалдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх, тэдний эдийн засаг, нийгмийн оролцоог дэмжихийг шаарддаг.

3. Хөдөлмөрийн эрхийн тухай олон улсын гэрээ (ILO No. 159)

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)[8]-ийн Хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын хөдөлмөрийн эрхийн тухай конвенц (ILO No. 159) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлд оролцоог дэмжих зорилгоор батлагдсан. Энэ конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг хангах, тэдний хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэдэг.

4. Олон улсын конвенцийн хууль, эдийн засаг, соёлын эрхийн тухай (ICESCR)[9]

---

[7] https://legalinfo.mn/mn/detail/1271
[8] International Labour Organization https://www.ilo.org/
[9] International Covenant on Economic, Social and Cultural Rights https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/international-covenant-economic-social-and-cultural-rights

Олон улсын Эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийн тухай конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийг хамгаалдаг. Энэ конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийн тухай конвенц нь бүх хүмүүст тэгш боловсрол, соёлын үйлчилгээг хүртээмжтэйгээр үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эдийн засгийн амьдралд оролцуулах талаар тусгадаг.

5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (WHO) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах бодлогын баримт бичиг” (2011)

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)-ийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах бодлогын баримт бичиг” нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлэх ёстой бодлого, үйл ажиллагааны зөвлөмжүүдийг агуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэгш хүртээмжтэй байх шаардлагатай бөгөөд эрүүл мэндийн бүх түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай үйлчилгээг бий болгох нь чухал.

Эдгээр хуулиуд, тогтоомжууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралыг сайжруулах, тэдний эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улс дэлхий дахинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох олон улсын гэрээнүүдэд нэгдэж, өөрийн хууль эрх зүйн орчныг сайжруулж байгаа нь энэ асуудалд чухал ач холбогдолтой.

Хүний эрхэд суурилсан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хүлээн зөвшөөрч, тэднийг ижил тэгш боломжтой байлгахыг зорьдог. Энэ онолын үндсэн зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бусад хүмүүсийнхтэй адил түвшинд хангах, ялгаварлан гадуурхалтыг халах явдал юм. НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь энэхүү хандлагын гол баримт бичгүүд юм (UN, 2006). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах эрхийг хангах зорилгыг хангах хүрээнд:

- ✓ Нийгмийн бүх салбарт оролцох нөхцөлийг бүрдүүлэх.
- ✓ Хууль эрх зүйн орчинд ялгаварлалгүй байдлыг баталгаажуулах шаардлага тавигддаг.

Нийгмийн оролцооны онол нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахад тэднийг нийгмийн идэвхтэй гишүүн болгохыг чухалчилдаг (Sen, 1999). Энэхүү онолын үндсэн үзэл санаа нь бэрхшээл бол хувь хүний сул тал бус, харин нийгмийн орчинд бүрдсэн саад тотгорын үр дүн гэж үзэх явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд оролцох боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах зорилгын хүрээнд (Barnes, 2012):

- ✓ Олон нийтийн хандлагыг өөрчлөх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүлээн зөвшөөрөх соёлыг түгээн дэлгэрүүлэх.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, үйлчилгээ бий болгохыг шаардана.

Хөгжлийн онолуудын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих нь зөвхөн хүний эрхийн асуудал биш, нийгмийн тогтвортой хөгжлийн гол нөхцөл гэж үздэг. Хүний хөгжилд суурилсан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшнийг сайжруулахад чиглэдэг (Oliver M. , 1990).

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах замаар нийгмийн баялгийг шударгаар хуваарилах.
- ✓ Тэдний нөөц бололцоог бүрэн дэмжихийн тулд бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.
- ✓ Эдийн засгийн өсөлтөд тэдний хувь нэмрийг үнэлж, хүлээн зөвшөөрөх юм.

Олон улсын туршлага:

1. Швед улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр дэлхийд тэргүүлэгч орны нэг юм. Тус улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг хангах хуулийн хатуу зохицуулалттай. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тусгай хэрэгцээт боловсролыг үнэ төлбөргүй авах эрхтэй (Swedish Institute, 2020) байдаг.
2. Канад улс “Хүн бүрт хүртээмжтэй Канад” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байранд оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна. Энэхүү хөтөлбөр нь нийтийн орчин, дэд бүтэц, тээврийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулахад чиглэдэг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

эрхийг хамгаалах хууль, журамтай бөгөөд тэдгээрийг хатуу мөрддөг (Government of Canada, 2019).

3. Япон улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого амжилттай хэрэгжиж байна. Ажил олгогч байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авахыг хуульчилж, шаардлагатай тохиолдолд татаас олгодог. Мөн технологид суурилсан дэд бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлж байна (Japan International Cooperation Agency (JICA), 2022).

Олон улсын туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах гол хүчин зүйл нь хууль, бодлогын хатуу зохицуулалт, нийгмийн орчин дахь хүртээмжийг хангах, нийгмийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ юм. Эдгээрийг Монгол Улсын нөхцөлд нутагшуулах боломжтой бөгөөд түүний тулд бодлого боловсруулагчид олон улсын жишээнээс суралцах нь чухал байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

2.1. Хүчирхийллийн эсрэг хууль, эрх зүйн орчин

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (2016 он) хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд учирч болох аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар заасан байдаг. Гэвч “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа” (IRIM, 2021) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 74% нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болох нь тодорхойлогдсон байна. Тодруулбал сэтгэл санаа, хянах зан үйл, бие махбод, эдийн засаг, бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа бөгөөд дийлэнх тохиолдолд эдгээр нь хавсарсан шинжтэй байна. Сэтгэл санааны хүчирхийлэлд бүх төрлийн бэрхшээлтэй хүмүүс, хянах зан үйлийн хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс, бие махбодын хүчирхийлэлд хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс, эдийн засгийн хүчирхийлэлд тулгуур эрхтэн, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс, бэлгийн хүчирхийлэлд хараа, сонсгол болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс илүү өртсөн байна.

Хүчирхийлэл нь олон төрлийн хэлбэртэй байдаг бөгөөд энэ нь бие махбодын, сэтгэл зүйн, бэлгийн болон эдийн засгийн хүчирхийллийг агуулдаг. Монгол Улсад болон дэлхий даяар хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн эрхийг хамгаалах зорилгоор олон хууль тогтоомжийг боловсруулсан. Тэгвэл сэтгэл зүйн хүчирхийлэл нь тухайн хүний сэтгэл санааг гэмтээж, сэтгэл зүйн болон сөрөг нөлөө үзүүлэх нь чухал бөгөөд энэ тал дээр тусгай хууль эрх зүйн зохицуулалтууд хийгдсэн байна.

Хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн орчин нь бүх төрлийн хүчирхийллийн (бие махбодын, сэтгэл зүйн, бэлгийн) эсрэг хуулиуд болон олон улсын гэрээнүүдээс бүрддэг.

Монгол Улсын хуулиуд[10]:

1. Монгол Улсын Үндсэн хууль нь хүн бүрийн амьдрах, бие махбодын болон сэтгэл санааны бүрэн бүтэн байдал, хувийн амьдралын нууц, эрх чөлөөг хамгаалахын тулд хүчирхийлэлд өртөөгүй байх эрхийг баталгаажуулдаг.
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2017) нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах зорилгоор батлагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэл агуулдаг бөгөөд тухайн хуулиар хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг хамгаалах, яаралтай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлсэн.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль нь хүчирхийллийн олон хэлбэрийг гэмт хэрэг гэж тооцож, гэмт хэргийн хариуцлага тооцохоор зохицуулалт хийсэн байдаг. Бие махбодын хүчирхийллийн хувьд хүний амь нас, бие махбодын бүрэн бүтэн байдалд халдсан үйлдлийг гэмт хэрэг гэж үздэг бол сэтгэл зүйн хүчирхийлэл нь тодорхой шалгууруар нотлогдож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой байдаг.

Олон улсын жишиг:

1. НҮБ-ын “Хүний эрхийн универсаль тунхаглал” нь бүх хүмүүсийн эрх чөлөө, бие махбодын болон сэтгэл зүйн бүрэн бүтэн байдал, нийгмийн харилцааны тэгш оролцоог хамгаалах үүрэг хүлээж буй олон улсын баримт бичиг юм. Сэтгэл зүйн хүчирхийлэл нь уг тунхаглалын хүрээнд харилцааны болон сэтгэл санааны эрхийг зөрчиж байгааг онцолж болно.
2. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийг хамгаалах, сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй тохиолдолд тусламж үзүүлэх үүргийг тухайн улсад хүлээлгэдэг.

[10] 1. Монгол Улсын Үндсэн хууль (1992).

2. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль (2016).

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль (2011).

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (2015).

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль (2018).

Сэтгэл зүйн хүчирхийлэл нь тухайн хүний сэтгэл санааг гэмтээж, удаан хугацааны турш сөрөг нөлөө үзүүлэх аюултай хүчирхийллийн хэлбэр юм. Энэ нь сэтгэл санаа, сэтгэцийн амар амгалан байдал, өөртөө итгэх итгэлд халдаж, олон төрлийн сөрөг нөлөө үзүүлдэг. Монгол Улсын хууль, тогтоомжид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Эрүүгийн хуульд орон нутгийн түвшинд сэтгэл зүйн хүчирхийлэлд хамаарах зүйлсийг илэрхийлэх хязгаарлалтууд байдаг. Эдгээр хуулиуд сэтгэл зүйн хүчирхийлэлтэй тэмцэх, тухайн хохирогчийг хамгаалах үүднээс яаралтай арга хэмжээ авах боломжийг хуулиар зохицуулж өгдөг. Гэхдээ сэтгэл зүйн хүчирхийлэл нь бусад хүчирхийлэлтэй харьцуулахад ихээхэн анхаарал хандуулж байгаа асуудал биш гэдгийг олон судалгаа харуулсан.

Монгол Улсын хууль эрх зүйн орчинд сэтгэл зүйн хүчирхийлэлд хамаарах тодорхой зохицуулалтууд байхгүй боловч гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрхийн асуудалд чиглэсэн олон улсын гэрээ болон хууль тогтоомжуудын хүрээнд арга хэмжээ авах боломжтой байдаг. Сэтгэл зүйн хүчирхийллийн эсрэг илүү тодорхой, хүчтэй хууль эрх зүйн зохицуулалтууд шаардлагатай байна. Эдгээр зохицуулалтууд нь сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй хүмүүсийг хамгаалах, тэдний эрхийг хангах зорилгоор хэрэгжүүлэх шаардлагатай юм.

2.2. Хүчирхийллийн хэлбэрүүд болон сэтгэл зүйн хүчирхийлэл

Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийллийн төрөл хэлбэрүүдийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. 6.2.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ.
2. 6.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.
3. 6.4.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах,

тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ.

4. 6.5.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ.

Бие махбодын хүчирхийлэл гэж гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусдадаа хяналтаа тогтоон, хамааралд оруулах зорилгоор биед нь халдан өвдөлт авчирч, бэртэл гэмтэл учруулах болон учруулж болзошгүй үйлдэл гаргах, эс үйлдэхийг хэлнэ. Бие махбодын хүчирхийллийн үр дагавар нүдэнд шууд харагдахуйц байдаг тул хүчирхийллийн энэ төрлийг хүн бүр мэддэг. Гэхдээ энэ нь хамгийн их хэрэглэгддэг хүчирхийллийн төрөл биш.

Гэр бүлийн гишүүн, сэтгэл зүйн болон ураг төрлийн хамааралтай хүний эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Бэлгийн сэдэлтэй үг хэл, онигоо ярих, зураг, кино, дүрс үзүүлэх, үнсэх, илж таалах, зөвшөөрөлгүй байхад харилцаанд орохыг албадах, бэлгийн хүслээ ёс бусаар хангах, зэвсэг эсвэл бусад зүйлийг ашиглан хүчирхийллийн шинжтэй зүйлд албадах, хүчиндэх болон хүчиндэхээр завдах.

Гэр бүлийн гишүүн өөр нэгэн гишүүний хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, тэтгэвэр, тэтгэмж, дундын эд хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарлахыг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ. Санхүүгийн нөөцийг хяналтдаа байлгах зорилгоор орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хаан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эд хөрөнгийн хохирол учруулсан аливаа үйлдэл, зан үйл хамаарна.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь хүний хүсэл бодлыг үл тоох, нэр хоч өгөх, гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, загнаж зандрах, гүтгэх, мөрдөх, бусадтай харилцах харилцааг хязгаарлах, хүний өөртөө итгэх итгэл болон амьдралд хандах хандлагыг үгүй хийх, заналхийлэх зэрэг болон энд дурдагдаагүй өөр олон хэлбэрээр илрэх боломжтой (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2021).

Хүчирхийлэлд өртсөний улмаас насанд хүрэгчдэд стресст үзүүлэх цочмог хариу урвал, гэмтлийн дараах стрессийн эмгэгүүд, дасан зохицохуйн хямрал,эмгэг,

диссоциатив/сэтгэцийн нэгдмэл байдал алдагдах/ ойгүйдэл, диссоциатив тэнүүчлэлт, диссоциатив хөшилт, ухаан бүрийтэн балрах эмгэг, хөдөлгөөний диссоциатив эмгэг диссоциатив таталт, мэдээгүйдэл ба мэдрэх эрхтний чадвар алдагдах эмгэг, органик бус нойрны эмгэг, танин мэдэхүйн өөрчлөлт, донтолт, сэтгэл гутрал, түгшүүр, хүчирхийллийн тойрогт орох, өөрөө хүчирхийлэгч болох, өөрийгөө хүчирхийлэх, амиа хорлох зан үйл зэрэг сэтгэцийн тулгамдсан асуудлууд болон бэрхшээлүүд үүсэж болзошгүй байдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИОЛДОЖ БУЙ СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙ

3.1. Сэтгэл зүйн хүчирхийллийг тодорхойлох аргачлал

Хүчирхийлэлд өртсөн эсэхийг судлахад янз бүрийн аргыг ашигладаг бөгөөд эдгээр нь чанарын болон тоон судалгааны арга зүйд суурилсан байдаг. Хүчирхийлэлд өртсөн эсэхийг судлахад ашиглагддаг жишиг аргачлалуудад нь Гэр бүлийн хүчирхийллийн судалгаанд өргөн хэрэглэгддэг бөгөөд бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийллийг хэмждэг Conflict Tactics Scale (CTS) болон тодорхой үйлдлүүдээр хүчирхийлэлд өртсөн байдлыг үнэлдэг Behaviorally-Based Screening Tools, EAC буюу Emotional Abuse Checklist (Henry, 2013) зэрэг юм. Энэхүү судалгаанд EAC-ийн 20 асуумжийг ашигласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолдож болзошгүй сэтгэл зүйн тулгамдсан асуудал буюу стресс, сэтгэл гутрал, түгшүүрийг илрүүлэх DASS-21 тестийг ашигласан.

3.1.1. Ярилцлагын арга

Ярилцлагын аргаар судлуулагчийн ерөнхий мэдээлэл болон нийгмийн амьдралын идэвх, өвчний оношь, хөгжлийн бэрхшээлийн шалтгаан, хүчирхийллийн талаар ерөнхий ойлголт, хүчирхийлэлд өртөж байсан түүх зэргийг тодруулах зорилготой. Ярилцлагын арга нь бусад судалгааны аргатай харьцуулахад дэлгэрэнгүй мэдээлэл, учир шалтгааны талаар гүн гүнзгий ойлголтыг өгдгөөрөө давуу талтай.

3.1.2. Хүчирхийллийг тодорхойлох EAC асуумж (Henry, 2013)

EAC-ийн товч асуумж (20 асуулттай хувилбар):

Энэ асуумж нь сэтгэл зүйн хүчирхийллийг богино хугацаанд илрүүлэх зорилготой. Хариултын гурван хувилбар нь: Тийм, Үгүй, Магадгүй

Асуултууд дараах 4 дэд хэсгийг хамардаг:

1. Эрх мэдлийн хяналт

Энэ хэсэг нь хүчирхийлэгчийн хохирогчийг хянах, эрх мэдлийг булаан авах үйлдлүүдийг хэмждэг. Энэ нь ихэвчлэн хохирогчийн шийдвэр гаргах, санхүүгийн байдал, нийгмийн оролцоонд нөлөөлдөг. Холбогдох асуултууд:

- Таны шийдвэр гаргах эрхэд хязгаарлалт тавьдаг уу?
- Таны санхүүгийн хэрэгцээг хянаж байсан уу?

- Таны өмнөөс бүхнийг шийддэг гэж боддог уу?
- Таныг бусадтай харилцахаас зайлсхийлгэдэг үү?
- Таныг гэр бүлийнхэндээ эсвэл найз нөхдөдөө очихыг хориглож байсан уу?

Үр дүнг үнэлэх: Эрх мэдлийн хяналтын асуултуудад Тийм гэж хариулах тоо их байх тусам хохирогч хүчирхийлэгчийн хяналтад орсон байх магадлалтай.

2. Доромжлол, буруутгал

Энэ хэсэг нь хохирогчийн өөртөө итгэх итгэлд халдаж, тэднийг буруутгах, доошлуулах зан үйлийг хэмждэг. Холбогдох асуултууд:

- Таныг “чадваргүй” гэж дорд үзэж байв уу?
- Таныг бусдын өмнө доромжилж байсан уу?
- Таныг өөрийгөө буруутгах байдалд хүргэдэг үү?
- Таныг “хэрэггүй хүн” мэт санагдуулдаг уу?
- Таны хийсэн зүйлсийг үргэлж шүүмжилдэг үү?

Үр дүнг үнэлэх: Доромжлолын асуултуудад Тийм гэж хариулах тоо өндөр байх нь хүчирхийлэлд өртсөн болохыг илтгэнэ.

3. Сэтгэл зүйн дарамт

Энэ хэсэг нь айдас төрүүлэх, сэтгэл санаяны тогтворгүй байдал үүсгэх үйлдлүүдийг хэмждэг. Холбогдох асуултууд:

- Таныг байнга хянаж, хязгаарлаж байсан уу?
- Танд айдас төрүүлэх үг хэллэг хэрэглэдэг үү?
- Таныг бусдын өмнө “хэрэггүй хүн” мэт санагдуулдаг уу?
- Таны бодлыг өөрчлөхийн тулд дарамталж байсан уу?

Үр дүнг үнэлэх: Сэтгэл зүйн дарамттай холбоотой Тийм хариултуудын тоо их байх нь хүчирхийлэлд өртөх өндөр магадлалыг илэрхийлнэ.

4. Бие даасан байдлыг хязгаарлах

Энэ хэсэг нь хохирогчийн өөрийн хүсэл, орон зай, эрх чөлөөг хязгаарлах зан үйлийг хэмждэг. Холбогдох асуултууд:

- Таны үзэл бодлыг байнга үгүйсгэдэг гэж та боддог уу?
- Танд “ энэ чиний хийх хэрэг биш” гэж ойлгуулдаг уу?
- Таны санал бодлыг сонсдоггүй гэж боддог уу?
- Таны зан үйлийг байнга хянаж байсан уу?
- Таныг ганцаардмал байдалд оруулахыг санаархаж байсан уу?

Үр дүнг үнэлэх: Бие даасан байдлыг хязгаарлах асуултуудын Тийм хариулт их байх нь хохирогчийг хүчирхийлэлд өртсөн болохыг илтгэнэ.

Үнэлгээний зарчим: Тийм хариултын тоо их байх тусам сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөх магадлал өндөр гэж үзнэ. Магадгүй хариултууд нь тодорхой бус байдлыг илтгэнэ, эдгээрийг нарийвчлан судлах шаардлагатай. Үгүй хариултууд хүчирхийлэлд өртөх эрсдэл багатайг илэрхийлнэ.

1. Дэд хэсгүүдийн онооны нийлбэр:
- Тус бүрийн дэд хэсгийн Тийм хариултуудын тоог тусад нь гаргана.
- Тухайн хэсэгт 5 оноо авах нь хохирогч тэр төрлийн хүчирхийлэлд хүчтэй өртсөнийг илтгэнэ.
2. Ерөнхий оноо:
- 20 асуултын нийт Тийм хариултын тоог нийлүүлж үнэлнэ.
- Нийт онооны дээд хязгаар 20 байх бөгөөд 10-аас дээш оноо авсан бол хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр гэж дүгнэнэ.
3. Магадгүй хариултыг үнэлэх:
- Магадгүй хариултуудыг тухайн хариултын учир шалтгааныг нарийвчлан тодруулахын тулд чанарын аргаар (жишээ нь, ярилцлагаар) судална.

Давуу тал: Энгийн ба ойлгомжтой: 20 асуулт нь хэрэглэгчдэд төвөг багатай. Түргэн үнэлгээ өгөх боломжтой: Өндөр магадлалтай тохиолдолд илүү гүнзгий аргачлал ашиглахад чиглүүлнэ. Хүчирхийллийн түвшнийг анхан шатанд тодорхойлох: Багц дүгнэлт гаргах замаар хүчирхийллийг ялган танихад тусална.

3.2. Сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх аргачлал

DASS-21 (Depression Anxiety Stress Scale) буюу сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хэмжүүрийн тест

1983 онд АНУ-ын Ловибонд Ш., Ловибонд П.Ф нар DASS-21 тестийг 42 асуулгатайгаар боловсруулжээ. Улмаар 1998 онд Антони М.М нар DASS-21 тестийн богино хувилбарыг боловсруулсан байдаг.

Тестийн зорилго нь сэтгэл гутрал, түгшүүр, стрессийг хэмжих бөгөөд хэмжүүр бүр 7 асуулттай нийт 21 асуулгатай. Асуулгад хариулахдаа “Надад тохиолдоогүй”, “Надад заримдаа буюу бага хэмжээгээр тохиолдсон”, “Надад тодорхой хэмжээгээр буюу тодорхой хугацаанд тохиолдсон”, “Надад маш олон тохиолдсон буюу ихэвчлэн тохиолдсон” гэсэн 4 хэмжүүрээр үнэлгээг өгнө. Судалгааг боловсруулахдаа боловсруулах хүснэгт ашиглах бөгөөд сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хувьд тус тусад нь хэвийнээс маш хүчтэй хүртэл 5 түвшинд ангилна. Тестийг клиникийн болон судалгааны зорилгоор ашиглах боломжтой.

Энэхүү тестийн эх хэл нь англи хэл бөгөөд 50 улсын хэлээр албан ёсоор орчуулагдсаны нэг нь монгол хэл юм[11]

Факторуудын коэффициент: сэтгэл гутрал 0.25-аас 0.61, түгшүүр 0.30-аас 0.53, стресс 0.31-ээс 0.51 хүртэл байдаг (Эрхэс, 2021). Баталгаат чанар 0.85-аас 0.81-ийн хооронд, зүйлүүдийн нийт корреляц хамаарал 0.25-аас 0.61 хооронд байна. Коронбах альфаг дотоод тогтвортой байдлын коэффициентүүд тус бүрд сэтгэл гутрал, түгшүүр, стрессээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхойлоход 0.96, 0.89 ба 0.93 байсан.

Хүснэгт 1. DASS-21 Боловсруулах хүснэгт

	Сэтгэл гутрал	Түгшүүр	Стресс
Хэвийн	0-4	0-3	0-7
Хөнгөн	5-6	4-5	8-9
Дунд зэрэг	7-10	6-7	10-12
Хүчтэй	11-13	8-9	13-16
Маш хүчтэй	14+	10+	17+

[11] http://www2.psy.unsw.edu.au/dass/translations.htm

Баталгаажуулагч хүчин зүйлийн шинжилгээ: Эхний түвшний баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээг DASS-21-ийн албан ёсны хувилбар дээр хийхэд индекс нь ($x2 = 2292.34$, $df = 814$, $RMSEA = .057$) гарсан нь үнэ цэнтэй үр дүн юм (Universal Journal of Educational Research 4(12): , 2016).

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИОЛДОЖ БУЙ СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн тохиолдол

Судалгааны датаг цуглуулсан судлаачид судалгаанд оролцогчдод хүчирхийллийн төрөл хэлбэрүүд, шинж тэмдгүүдийг тайлбарлаж өгсний дараа ярилцлагын аргаар хүчирхийлэлд өртсөн тохиолдлуудын мэдээллийг цуглуулсан. Судалгаанд нийт 100 хүн хамрагдсанаас 60 нь өөрийгөө сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн гэж тодорхойлсон. Үүнээс өөрийн түүхийг хуваалцахыг зөвшөөрсөн 11 эмэгтэй, 7 эрэгтэй, нийт 18 судлуулагчийн тохиолдлыг хүргэж байна.

Тохиолдол 1. 23 настай, Сонсголын бэрхшээлтэй, бүрэн дунд боловсролтой эрэгтэй:

Гэр бүлийнхэн маань хаяа миний санал бодлыг авч хэлэлцэхгүй, огт тоохгүй үл ойшоох хандлага гаргадаг. Ойр зуурын хэрэглээний зүйлс авах талаар асуухад төвөгшөөсөн дургүй байгаа нь мэдэгддэг болохоор хэцүү байдаг. Хурдан тусдаа гарч хүнээс хараат бус амьдрахыг хүсдэг. Гэр бүлийнхэн маань арай илүү анхаардаг тусалж дэмждэг байсан бол арай идэвхтэй амьдрах байсан юм шиг санагддаг.

Тохиолдол 2. 27 настай, Тархины саажилттай, бага боловсролтой эмэгтэй:

Аав, ээж найз нөхөдтэй бол гэсэн болохоор сүмд явж эхэлсэн. Аав ээж байнга хүргэж өгч, тарах үед авдаг. Тийм болохоор хүмүүс ихэнхдээ чи нөхөр, хүүхэдтэй юу гэж асуудаг. Байхгүй гэхээр хүнтэй унтсан юм уу, ер нь үзсэн үү гэж залуучууд их асуудаг. Тэр нь ядаргаатай, хэцүү санагдаад байдаг. Гадуур ганцаараа явахад хүмүүс хараад байхаар эвгүй санагддаг. Энэ талаараа ээж аавдаа хэлж чаддаггүй. Бас гэр хороололд амьдардаг болохоор шороон замаар явж чаддаггүй болохоор ихэвчлэн хар замаар явах хэрэгтэй болдог. Тэр үеэр машины жолооч нар хараах, уурлаж харилцах нь хэцүү байдаг. 1 өдөр ганцаараа явж байхад согтуу эрэгтэй хүн зочид буудал хамт оръё гэж араас дагаад байсан. Айснаасаа болоод гэнэт унаад ачааны машинд дайруулахаа шахсан. Бусдаар гэр бүлд ямар нэгэн асуудал байхгүй. Гэр бүлийнхэн маань маш сайн дэмждэг.

Тохиолдол 3. 25 настай, Тархины саажилттай, бага боловсролтой эрэгтэй:

Эргэн тойрны хүмүүс болон хүрээлэл маань хэдий миний байгаа байдалд дассан ч гадуур явахад хүмүүс их гайхаж хардаг алхаа гишгээ гэх мэт энэ нь намайг бусад хүмүүсээс тусгаарлаж байгаа мэт муухай санагддаг.

Тохиолдол 4. 48 настай, Харааны бэрхшээлтэй, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

Нөхөртэйгөө сууснаас хойш хэсэг хугацааны дараагаас хоорондоо маргалддаг болсон жил өнгөрөх тусам ямар нэг асуудал дээр байнга маргалддаг болсон байсан Нөхөр маань архи бас уудаг уусан үедээ маргалдаж үүнээсээ болж намайг зоддог байсан. Баруун нүд рүүгээ цохиулснаас хойш тэр нүд юм сайн хархаа байсан Сүүлд 2021 оны 6 7 сарын хавьцаа байхаа нөхөртэйгөө бараг өдөр болгон шахуу хэрэлддэг байсан би ч бас үгээр их доромжилдог байсан нэг өдөр нөхөр тэсэлгүй зүүн нүдийг маань цохисон би тэр үед шоконд оролд юу болоод байгааг мэдээгүй маш их өвдөж байсан. Яаралтай тусламжаар эмнэлэгт очиход нүдний цөцгий урссан, эмчлэгдэх ямар ч найдваргүй гэсэн. Нөхөр маань эмчилгээний зардал олох гээд ажил хийсэн ч эмчлэгдэх ямар ч боломжгүй гэсэн одоо бүрэн хараагүй болсон.

Тохиолдол 5. 48 настай, Нурууны хугаралтай, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

Нөхөртэйгөө сууснаас хойш санхүүгийн асуудлаар их маргалддаг байсан би ч нөхрөө элдвээр хэлнэ тэр ч намайг элдвээр хэлдэг байсан. Хүүхдүүдээ маш их загнадаг хараадаг байсан. Хүүхдүүд том болох тусам намайг их харааж хэрэлддэг болсон зарим үед цохих гэж байгаа юм шиг санагддаг. Элдвээр харааж зүхэх нь их болсон. Одоо хүүхдийнхээ өөдөөс юм хэлж чаддаггүй.

Тохиолдол 6. 23 настай, Нуруу нугасны гэмтэлтэй, дунд боловсролтой эмэгтэй:

16 насанд нурууны гэмтэлүүсэж, нуруу нугасны гэмтэл гэж оношлуулсан. Маш их найзуудтай, найз хөвгүүнтэй байсан боловч хөгжлийн бэрхшээлтэй болсноос хойш найзууд нь холбоогоо тасалж, найз хөвгүүн нь чам шиг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ирээдүйгээ төсөөлөхгүй байна гээд салсан. Үүнээс хойш гэрээсээ гарахаа больж, нийгмийн харилцаанд орохоо больж сэтгэл нь маш ихээр хямарч эхэлсэн. Ээж ахын хамт амьдардаг, асаргаа шаардлагатай. Ах сэтгэл санааны хүчирхийлэл үйлддэг ба хэнд ч хэрэггүй амьтан гэх мэтээр байнга үг хэлээр доромжилдог. Хөгжлийн бэрхшээлтэй болсон эхэн үед ээж нь маш их санаа тавьж, эмнэлэг дагуулж явж, ихэд халамжилдаг байсан ч одоо тоохоо больсон ба эдийн засгийн хүчирхийлэл үйлддэг. Халамжийн мөнгө авдаг ч ээж хоол унданд зарцуулаад дууссан гэх шалтгаанаар хүссэн зүйлийг нь авч өгдөггүй. Шинэ хувцас, эдлэл хэрэглэл авахыг хүсэвч ээж гэрээс гарахгүй байж шинэ юмаар яах гээд байгаа юм гээд хуслийг нь сонсдоггүй.

Тохиолдол 7. 28 настай, Тархины саажилттай, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

Хүнтэй гэрлэж байсан. Нөхөртэйгөө эцэг эхээсээ тусдаа амьдардаг байсан ба нөхөр хүчирхийлдэг байсан. Сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэлд өртдөг байсан бөгөөд нөхөр нь надаас салсан ч чамайг хайрлах хүн олдохгүй, чи хэнд ч хэрэггүй гэх зэргээр үг хэлээр доромжилдог, гаж байдлаар бэлгийн харилцаанд орохыг шаарддаг байсан. Үүнээс үүдэж байнгын дарамтыг мэдэрч 2 жилийн өмнө нөхрөөсөө салсан.

Тохиолдол 8. 25 настай, Нуруу нугасны гэмтэлтэй, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

Анх 2019онд жирэмсэн болж анхны хүүхдээ төрүүлэхдээ буруу дүлэлт, төрөхийн хүндрэлээс шалтгаалан нуруу нугасандаа гэмтэлтэй болсноор хөгжлийн бэрхшээлтэй болсон. Нөхөр түүнээс шалтгаалан сэтгэлзүйн хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэл зэргийг үйлдэх болсон. Тухайлбал нялх хүүхэдтэй, төрсний дараах хямралтай үед доромж үгээр гутаан доромжлох, хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар эргэн тойрны хүмүүстээ элдвээр хэлэх, шөнө оройн цагаар согтуурхсан үедээ биед нь халдах, гэмтээх, хоол хүнсний дутагдалд оруулах зэргээр олон тооны давтамжтай хүчирхийлэл үйлдэж байсан.

Тохиолдол 9. 30 настай, Нуруу нугасны гэмтэлтэй, дээд боловсролтой эмэгтэй:

2015 онд авто машины осолд орж нугасаа гэмтээснээс болж хөгжлийн бэрхшээлтэй болсон. Найз залуутайгаа хамтдаа амьдардаг байхдаа хүчирхийлэлд өртдөг байсан байж болзошгүй буюу санхүүгийн хувьд түүнээс хараат байсан. Санхүүгийн хүчирхийллээс гадна бие махбодын хүчирхийлэлд өртдөг байсан. Найз залуу маань намайг цохиж гэмтээх, хөгжлийн бэрхшээлтэй гэдэг статусаар нь харьцаж ханддаг байсан. Тиймээс найз залуугаасаа салах шийдвэр гарган 2019 оноос ганцаараа амьдарч байгаа.

Тохиолдол 10. 45 настай, Төрөлхийн хэл ярианы бэрхшээл, биеийн хэсэгчилсэн саажилттай, бүрэн дунд боловсролтой эрэгтэй:

Төрөлхийн хэл ярианы бэрхшээлтэй ба бага байхаас хүүхдүүд шоолж, доромжилдог байсан. Гэр бүлийн хувьд хүчирхийлэлд өртөж байгаагүй ч харин бага насны хүүхдүүд маань надаас ичих, найзуудынхаа хажууд надтай хамт байхаас зайлсхийдэг нь хэцүү санагддаг. Залуу байхад гудамж тайлбай, нийгмийн хүрээлэлд намайг шоолох, шивнэж инээлдэх, доромжлох, зарим тохиолдолд чулуу ч шидүүлдэг үе байсан. Харин одоо орчин үед хүмүүс ухамсартай болж тиймэрхүү сөрөг үйлдэл гаргах нь багассан, өөрөө ч анзаарахаа больсон.

Тохиолдол 11. 22 настай, нуруу нугасны гэмтэлтэй, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

2013 онд зам тээврийн осолд орж нугасаа гэмтээсний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон. Уг осолд орох үед өвөрөө болон гэр бүлийнхэн нь цочролд орсон ба харилцааны хувьд асуудлууд тулгарсан. Гэр бүлийн гишүүд надтай харилцах үедээ санаандгүй байдлаар сэтгэл санааны хүчирхийллийн үйлдлүүдийг гаргадаг байсан. Гэр бүлийнхэн хичээлд хүргэж өгч чадахгүй үеүд цөөнгүй байдаг байсан. Бусдын гарыг харж алдаг оног сурч төгссөн. Их сургуульд орж чадсан ч мөн л сургууль руу явах, гэртээ ирэх зэрэг наад захын зүйлс хүртэл асуудал хэвээрээ л байсан. Цаашлаад үе тэнгийнхний гадуурхалд хүртэл өртөж байсан. Гэр бүлийнхний туслалцаа дэмжлэг үзүүлэх нь улам багассан. Хичээлдээ гэрийнхнийхээ боломжийг харж байж суралцдаг болсон. Мөн өөрийнхөө хүслийг хэлбэл хориглох, хувцас авна гэвэл миний санаа бодлыг сонсохгүй байх, гадуур авч явахаас цааргалах зэргээр илэрдэг.

Тохиолдол 12. 30 настай, Төрөлхийн саажилттай, бага боловсролтой эрэгтэй:

Эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг. Эцэг эх нь орлого муутай учраас оролцогчийн халамжийн мөнгийг авдаг. Өөрийнх нь хэрэгцээ шаардлагатай зүйлст (эм тариа, хувцас) зарцуулдаггүй.

Тохиолдол 13. 36 настай, Нуруу нугасны гэмтэлтэй, дээд боловсролтой эмэгтэй:
Залуудаа хөгжлийн бэрхшээлтэй болсон тул хүмүүсийн хандлагад их эмзэг байсан. 15настай 1 хүүтэй, ганц бие. Хүүгийн эцэгтэй гэр бүл болоогүй. Одоо ээж, хүүгийн хамт амьдардаг. сэтгэл санааны хүчирхийлэлд их өртдөг хөгжлийн буюу хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс рүү гадуур явахад эргэж харах шивнэлдэх тохиолдлууд их гардаг караоке, ресторан зэрэг үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхэд бүр ч их гайхсан байдалтай харагддаг.
Тохиолдол 14. 22 настай, Төрөлхийн тархины саажилттай, унаж татдаг өвчтэй, хэл ярианы бэрхшээлтэй боловсролгүй эрэгтэй /Гэр бүлийн гишүүнтэй ярилцсан/:

Уур бухимдлаа ямар нэгэн эд зүйл авч шиддэг, ах, эгчийнхээ үснээс зулгаах, орилох, бага насны хүүхдэд идэх зүйл өгдөг. Хөгшин настай хүнтэй гар барьж, хацар дээрээ үнсүүлэх, өмссөн малгайг нь авч зугтаах зэрэг үйлдлүүдийг үзүүлдэг. Халуун цайг хүйтэн юм шиг маш хурдан уудаг. 15 настайдаа газраас чулуу авч хажуу айлын хүүхдийн толгойг хагалж байсан. Энгийн үед гадаа нарлаж суух дуртай, утсан дээр дуу сонсох бүжиглэх гэх мэт. Аймгийн төвд амьдардаг байхдаа гэрийнхээ хашааны хойд хаалгаар гарч яваад 3,4 цаг алга болчихдог байсан. Дэлхийн зөнд хамрагдаж тусламжийн эд зүйл

авдаг байсан. Цагаан голын рашаанд эмчлүүлэх гэж явсан боловч зүгээр болоогүй. Ямар нэгэн эмнэлгийн эмчилгээ авч байгаагүй, уламжлалтын аргаар хэд хэдэн удаа рашаан сувилалд явж байсан. Одоо аав ээжтэйгээ хөдөө мал маллаж амьдардаг.

Тохиолдол 15. 64 настай, Хүзүү болон нуруу нугасны гэмтэлтэй, дунд боловсролтой эрэгтэй:

2015 онд эхнэр нас барж, их хэмжээний сэтгэл гутралд орсон. Хий бодолд маш их автдаг байсан. 2 дахь хүү болон бэртэйгээ таарамж муутай байдаг ба хаяа эд хөрөнгийн дарамтад ордог. Тэтгэврийн зээлээрээ хүүхдүүддээ машин авч өгснөөс хойш сэтгэл зүйн дарамт авах нь багассан.

Тохиолдол 16. 35 настай, Хөл болон нуруу нугасны гэмтэлтэй, дээд боловсролтой эрэгтэй:

2011 онд осолд орж хөл болон нугасаа гэмтээснээс болж хөгжлийн бэрхшээлтэй болсон. Гэрийнхэнтэйгээ хамт амьдарч байгаад 2018 онд тусдаа ганцаараа бие дааж амьдрах болсон. Гэрийнхэнтэйгээ хамт амьдарч байх явцад гэр бүлийн гишүүд өөрсдөө санаандгүй байдлаар сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл үйлддэг байсан. Тухайлбал өөрийнхөө хүслийг хэлбэл хориглох, хувцас авна гэвэл миний санаа бодлыг сонсохгүй байх, эм, тариа авах, эмчилгээ хийлгэнэ гэх үед мөнгө санхүүгээр дэмжлэг үзүүлэхгүй байх зэргээр илэрч байсан. Хамтрагч маань миний хүсэл сонирхлыг нь харгалзаж үзэхгүй, хүсэхгүй байгаа үйлдэл, хөдөлгөөн хийж бэлгийн харилцаанд ордог байсан. Нугасны гэмтлээ эдгээхийн тулд бөө дээр очиж 2 жил дасгал хийж, уламжлалт эмчилгээ хийлгэсэн бөгөөд тухайн бөө нь чи амрахгүйгээр нөхөн сэргээх эмчилгээгээ сайн хийлгэх ёстой гэж олон цагаар дасгал хийлгэж, гар утас, телевиз, зарим хоол хүнсийг хориглож бие болон сэтгэл зүйн хүчирхийлэл үйлддэг байсан. Тэр үед яг шоронд байгаа юм шиг санагдаж байсан ч гэр бүлийнхээ итгэл найдварыг алдахгүйн тулд өөрт нь хэцүү байгаагаа хэлж чаддаггүй байсан. Анх хөгжлийн бэрхшээлтэй болсны дараа гадуур явахад хүмүүсийн хандлагад эмзэглэж ямар хариу үйлдэл үзүүлэхээ мэдэхгүй хэцүү байсан ч одоо хүчирхийллийн талаар илүү сайн мэдлэгтэй болсон учраас хүмүүсийн хандлагыг яаж хүлээнэ авч, ямар хариу үйлдэл үзүүлэхээ мэддэг болсон. 2018 оноос хойш сэтгэл зүй, бие махбод, эдийн засгийн хүчирхийлэлд өртөөгүй бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байх магадлалтай.

Тохиолдол 17. 37 настай, Төрөлхийн түнхний мултралтай, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:


Төрөлхийн түнхний мултралтай бөгөөд анхны хүүхдээ төрүүлсний дараагаар хөл бүр илүү гажиж алхахад хэцүү болсон. Нөхөртэйгөө байнгын хэрүүл маргаантай харилцаатай байсан. Нөхөр анхны хүүхэд 2 сартай байх үеэс зодож, доромжилдог байсан бөгөөд үүнийгээ өөрийн аав ээждээ эхлээд хэлэхгүй нууж явсаар олон давтамжтай хүчирхийлэлд өртөж нөхрөөсөө салсан. Өөрийгөө хүчирхийлэлд өртөж буйгаа мэдэхгүйгээр нөхрийгөө тэвчиж, уучилж байсан бөгөөд одоо хоёр хүүхэдтэйгээ өөрийн төрж өссөн гэртээ амьдардаг, хаяадаа нөхөртэйгөө уулзаж хүүхдийн тэтгэмжийн мөнгө авах гэж маргалддаг.

Тохиолдол 18. 40 настай, Төрөлхийн хэл ярианы бэрхшээлтэй, хэсэгчилсэн биеийн саажилттай, бүрэн дунд боловсролтой эмэгтэй:

Бага байхаас хүүхдүүд шоолж, доромжилдог байсан. Ээжтэйгээ хамт амьдардаг, хүчирхийллийн аль нэг төрлөөр гэр бүрийн орчинд хүчирхийлэлд өртөж байгаагүй. Найз залуутай ба тэр хүн нь бас адилхан хөгжлийн бэрхшээлтэй учраас ойлголцоход амар байдаг. Энэ хүний хувьд гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртдөггүй, харин гадуур явах, автобусанд явах, төрийн болон хувийн албан байгууллагуудаар үйлчлүүлэх зэрэгт хүмүүсийн хандлага эхэндээ түүнд хэцүү санагддаг байсан одоо бол илүү сэтгэлийн хаттай болж зарим зүйлсийг тоохгүй өнгөрөөдөг болсон.

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн хүчирхийллийг судалсан үр дүн

График 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа




Судалгаанд 19-62 насны (32.4±8.3) 100 хүн хамрагдсан бөгөөд 40% нь эрэгтэй, 60% нь эмэгтэй байна.

График 2. Боловсролын түвшин



Судалгаанд оролцогчдын 7.5% нь бага боловсролтой, 41% нь бүрэн дунд боловсролтой, 10.2% нь тусгай боловсролтой, 41.3% нь дээд боловсролтой байна. Тэдний 63.5% нь мэргэжил эзэмшсэн, 36.5% нь мэргэжил эзэмшээгүй.

График 3. Судалгаанд оролцогчдын нийгмийн идэвх /Өөрийн үнэлгээ/



Судалгаанд оролцогчид өөрийн нийгмийн амьдралын идэвхйг 37% нь сул, 31% нь дундаж, 32% нь сайн гэж үнэлсэн бөгөөд 40.5% нь хөдөлмөр эрхэлдэг, 55.1% нь хөдөлмөр эрхэлдэггүй, 4.4% нь оюутан байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлийн төрөл ба асаргаа шаардлагатай эсэх

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Асаргаа шаардлагатай	Асаргаа шаардлагагүй	Нийт
Оюуны бэрхшээл	0	11	11
Хэл ярианы бэрхшээл	13	1	14
Хөдөлгөөний бэрхшээл	47	17	64
Бусад	4	7	11
Нийт	64	36	100

Судалгаанд оролцогчдыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөх ангилбал 11% нь оюуны бэрхшээлтэй, 14% нь хэл ярианы бэрхшээлтэй, 64% нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 11% нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Тэдний 64%-д асаргаа шаардлагатай, 36%-д асаргаа шаардлагагүй байна. Судалгаа авах, ярилцлага хийх боломж нөхцөлөөс шалтгаалан хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан хүчирхийлэлд өртөх байдал ялгаатай эсэхийг шинжилж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа (p>0.05) илрээгүй.

Хүснэгт 3. Хүчирхийллийн асуумжийн дундаж оноо

	Түүвэр	Дундаж утга	Стандарт хазайлт	Т тоо	*P* утга
Хүчирхийлэл	100	16.38	4.45	66.16	<0.001

Судалгаанд оролцогчид 20 асуулттай асуумжид дунджаар 16.4 оноо авсан нь дундаж оноо 10-аас статистикийн ач холбогдолтой түвшинд ялгаатай (p<0.001) буюу хэт өндөр байгааг илэрхийлж байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэ хүчирхийлэлд өртөх нь нийт хүмүүсээс ноцтой түвшинд байгаа нь батлагдаж байна.

Хүснэгт 4. Өөрийн үнэлгээнээс шалтгаалж хүчирхийллийн тестийн оноо

	Өөрийн үнэлгээ	Түүврийн тоо	Дундаж утга	Стандарт хазайлт	*P* утга
Хүчирхийлллийн асуумж	Өртсөн	71	18.2	2.7	
	Өртөөгүй	29	11.9	4.6	<0.001

Судалгаанд оролцогчоос “та бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэлд хэзээ нэг цагт өртөж байсан уу?” гэж асуухад 71% нь “тийм”, 29% нь “үгүй” гэж хариулав. Гэвч судлуулагчдаас авсан хүчирхийллийн асуумжид 10 онооноос илүү оноо авсан буюу хүчирхийлэлд өртдөг судалгаанд оролцогчид 89%-ийг эзэлж байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 18% нь хүчирхийлэлд өртдөг болохоо мэдэхгүй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 5. Хүйсээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал ялгаатай эсэхэд шинжилгээ хийсэн үр дүн

	Хүйс	Түүвэр	Дундаж утга	Стандарт хазайлт	*P* утга
Хүчирхийлэл	Эрэгтэй	40	16.3	4.5	0.904
	Эмэгтэй	60	16.3	4.3	
Эрх мэдлийн хяналт	Эрэгтэй	40	3.9	1.4	0.637
	Эмэгтэй	60	3.9	1.4	
Доромжлол ба буруутгал	Эрэгтэй	40	4.4	1.1	0.951
	Эмэгтэй	60	4.4	1.1	
Сэтгэл зүйн дарамт	Эрэгтэй	40	4.2	1.1	0.493
	Эмэгтэй	60	4.3	1.03	
Бие даасан_байдлыг хязгаарлах	Эрэгтэй	40	3.6	1.4	0.665
	Эмэгтэй	60	3.6	1.3	

Судалгаанд оролцогчдын хүчирхийлэлд өртөж буй байдал нь хүйсээс шалтгаалан ялгаатай эсэхийг хоёр бүлгийн ялгаа үзэх статистик шинжилгээний арга ашиглан шалгахад статистик ач холбогдол бүхий ялгаа (p>0.05) илэрсэнгүй. Өөрөөр хэлбэл, эрэгтэй болон эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүчирхийлэлд өртөж буй байдал аль аль нь өндөр байна. Хүчирхийллийг илрүүлэх асуумжийн 20 асуултад оролцогчид дунджаар 16-аас дээш удаа тийм гэсэн хариулт өгсөн байна. Тус асуумжийн дөрвөн бүрдэл хэсэг нь 5 асуулттай бөгөөд оролцогчид бие даасан байдлыг хязгаарлах тухай асуулгуудад дунджаар 3.6±1.4, эрх мэдлийн хяналтын тухай асуулгуудад дунджаар 3.9+1.4, сэтгэл зүйн дарамтын тухай асуулгуудад дунджаар 4.25+1.07, доромжлол ба бургуултгалын тухай асуулгуудад дунджаар 4.4+1.1 удаа тус бүр тийм гэсэн хариулт буюу энэ төрлийн хүчирхийлэлд өртдөг гэсэн хариулт өгсөн байна.

Хүснэгт 6. Нас болон хүчирхийллийн харилцан хамаарал

		Эрх мэдлийн хяналт	Доромжлол ба буруутгал	Сэтгэл зүйн дарамт	Бие даасан байдлыг хязгаарлах	Хүчирхийлэл
Нас	Хамаарлын коэффицент	-.348**	-.299**	-.374**	-.373**	-.381**
	P утга	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001


Нас болон хүчирхийлэл, түүний бүрдэл хэсгүүд хамааралтай эсэхийг шалгаж үзэхэд бүх хувьсагч настай статистик ач холбогдол бүхий урвуу сул хамааралтай (p<0.001) байна. Үүнээс нас залуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүчирхийлэлд өртөх түвшин илүү өндөр байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 7. Нас нь хүчирхийлэлд өртөхөд хэрхэн нөлөөлж буйг шалгасан үр дүн

	R	R^2	AR	f	*p* утга	Beta
Эрх мэдлийн хяналт	-0.384**	0.121	0.121	293.2	$p<0.001$	-0.057
Доромжлол ба буруутгал	-0.299**	0.089	0.089	208.5	$p<0.001$	-0.039
Сэтгэл зүйн дарамт	-0.374**	0.140	0.140	346.5	$p<0.001$	-0.049
Бие даасан байдлыг хязгаарлах	-0.373**	0.139	0.139	343.8	$p<0.001$	-0.059
Хүчирхийлэл	-0.381**	0.145	0.145	361.2	$p<0.001$	-0.204

Нас нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийлэлд өртөхөд хэрхэн нөлөөлж байгааг нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар шинжилж үзэхэд нас нэгээр нэмэгдэхэд эрх мэдлийн хяналт 0.057 нэгжээр, доромжлол ба буруутгал 0.039 нэгжээр, сэтгэл зүйн дарамт 0.049 нэгжээр, бие даасан байдлыг хязгаарлах нь 0.059 нэгжээр, хүчирхийллийн нийлбэр оноо нь 0.204 нэгжээр тус бүр буурах нөлөөг үзүүлдэг байна.

График 4. Боловсролын түвшнээс шалтгаалан хүчирхийлэлд өртсөн байдал ялгаатай эсэхийг шинжилсэн үр дүн



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүчирхийлэлд өртөж буй байдал нь боловсролын түвшнээс шалтгаалан ялгаатай эсэхийг шинжилж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ($p<0.001$) илэрсэн юм. Үр дүнг дэлгэрүүлэн бүлэг тус бүрийн хооронд ялгаа байгаа эсэхийг шалгахад эрх мэдлийн хяналт бага болон тусгай боловсролтой иргэд (m=3.7) эрх мэдлийн хяналт төрлийн хүчирхийлэлд өртөх нь бүрэн дунд болон дээд боловсролтой (m=3.9) хүмүүстэй харьцуулахад бага байна. Бусад хүчин зүйлсийн хувьд тусгай боловсролтой иргэд бага боловсролтой, бүрэн дунд

боловсролтой, дээд боловсролтой иргэдээс хүчирхийлэлд өртөх нь бага гэсэн үр дүн гарсан юм.

Хүснэгт 8. Боловсролын түвшин ба бусад ерөнхий мэдээллийн хамаарал

		Бага боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Тусгай боловсролтой	Дээд боловсролтой	*P* утга	Хамаарал/ Нөлөөлөл
Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Оюуны	0	2	1	6	<0.001	0.354
	Хэл ярианы	5	7	3	0		
	Хөдөлгөөний	1	22	14	29		
	Бусад	0	6	0	4		
Асаргаа	Шаардлагатай	6	28	14	28	0.511	-
	Шаардлагагүй	0	9	4	11		
Мэргэжилтэй эсэх	Тийм	0	13	15	39	<0.001	0.581
	Үгүй	6	24	3	0		
Хөдөлмөр эрхлэлт	Тийм	1	14	9	22	0.163	-
	Үгүй	5	20	7	17		
	Оюутан	0	3	2	0		
Нийгмийн идэвх	Сайн	0	6	13	19	<0.001	r=-0.410**
	Дунд	2	18	3	8		
	Сул	4	13	2	13		
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	0	9	20	5	<0.001	0.362
	Ганц бие	6	22	5	7		
	Салсан	0	0	5	0		
	Бэлбэсэн	0	6	9	6		
Хүчирхийллийн тухай ойлголт	Сайн	0	11	12	21	<0.001	r=-0.341**
	Дунд	4	15	4	12		
	Сул	2	11	2	6		

Өмнөх үр дүнг дэлгэрүүлэн тайлбарлах зорилгоор боловсролын түвшин ба хөгжлийн бэрхшээлийн төрөл хоёрын хамаарлыг хи квадратын шинжилгээний аргаар шалгахад ач холбогдол илэрсэн (p<0.001) ба хөгжлийн бэрхшээлийн төрөл нь боловсролын түвшинд 35.4%-ийн нөлөө үзүүлж байна. Тодруулбал, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд өндөр боловсрол эзэмших, хэл ярианы бэрхшээлтэй иргэд бага боловсрол эзэмших давтамж нь олон байна. Гэрлэлтийн байдал болон боловсролын түвшинд мөн ач холбогдол илэрсэн (p<0.001) ба боловсролын түвшин нь гэрлэлтийн байдалд 36.2%-ийн нөлөө үзүүлдэг байна.


Боловсролын түвшин ба нийгмийн идэвх нь урвуу дундаж (r=-0.410**) хамааралтай буюу боловсролын түвшин нэмэгдэхэд нийгмийн идэвх буурдаг байна. Боловсролын түвшин ба хүчирхийллийн тухай ойлголт нь эерэг сул (r=0.341**) хамааралтай буюу боловсролын түвшин нэмэгдэхэд хүчирхийллийн тухай ойлголт нэмэгддэг байна.

Мэргэжилтэй эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал (p<0.001) ялгаатай. Мэргэжил эзэмшсэн хүмүүс (15.7±4.8) мэргэжил эзэмшээгүй хүмүүсээс (17.8±3.1) хүчирхийлэлд өртөх байдал бага байна.

Боловсролын түвшин ба асаргаа шаардлагатай эсэх (p>0.05), хөдөлмөр эрхлэлт (p>0.05) зэрэг нь статистик ач холбогдолгүй байна.


Хөдөлмөр эрхэлдэг эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй түвшин статистик ач холбогдол бүхий ялгаагүй (p>0.05) байна.

График 5. Хүчирхийллийн тухай ерөнхий ойлголтоос шалтгаалан хүчирхийлэлд өртөх байдал ялгаа



Хүчирхийллийн тухай ерөнхий ойлголтоос шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал ялгаатай эсэхийг нэг хүчин зүйлийн ANOVA шинжилгээний аргаар шинжилж үзэхэд доромжлол ба буруутгал (p>0.05) хувьсагчаас бусад хувьсагчийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай (p<0.05) байна. Дундаж утгаас харахад хүчирхийллийн тухай ойлголт сайн хүмүүс хүчирхийлэлд өртөх нь бусад бүлгээс бага байна.

График 6. Асаргаа шаардлагатай эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдлын ялгаа




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өдөр тутамд нь бусдын асаргаа, тусламж шаардлагатай эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал ялгаатай эсэхийг хоёр бүлгийн ялгаа үзэх статистик шинжилгээний аргаар шалгаж үзэхэд хүчирхийллийн ерөнхий оноо (p<0.001) түүний бүрэлдэхүүн хэсэг тус бүрт статистик ач холбогдол бүхий ялгаа (p<0.001) илэрсэн байна. Тодруулбал, асаргаа шаардлагагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн илүү хүчирхийлэлд өртсөн байна.

Хүснэгт 9. Хүүхэдтэй эсэхээс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал

	Хүүхэдтэй эсэх	Дундаж утга	*P* утга
Эрх мэдлийн хяналт	Тийм	3.5	<0.001
	Үгүй	4.4	
Доромжлол ба буруутгал	Тийм	4.3	0.043
	Үгүй	4.6	
Сэтгэл зүйн дарамт	Тийм	4.02	0.004
	Үгүй	4.6	
Бие даасан байдлыг хязгаарлах	Тийм	3.4	0.003
	Үгүй	3.9	
Хүчирхийлэл	Тийм	15.2	0.003
	Үгүй	17.5	

Гэрлэлтийн байдлаас шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдалд статистик ач холбогдол бүхий ялгаа (p>0.05) илрээгүй. Харин хүүхэдтэй эсэхээс шалтгаалсан статистик ач холбогдолтой ялгаа ажиглагдаж байна. Тодруулбал, хүүхэдгүй хүмүүс хүчирхийлэлд өртөх байдал илүү байна.


График 7. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй түвшний ялгаа



Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан хүчирхийлэлд өртөж буй байдал ялгаатай эсэхийг олон бүлгийн ялгаа үзэх статистик шинжилгээний аргаар шинжилж үзэхэд хүчин зүйл зүйл тус бүр статистик ач холбогдол бүхий ялгаатай (p<0.001) байна. Тодруулбал, оюуны бэрхшээлтэй иргэд хамгийн их хүчирхийлэлд өртдөг, дараа нь хэл ярианы болон бусад төрлийн бэрхшээлтэй хүмүүс хүчирхийлэлд өртдөг бол хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийлэлд өртөх байдал бусад 3 бүлгээс бага байна. Судалгаанд оролцогчдыг ангилсан 4 төрлийн хөгжлийн бэрхшээлийн бүлэг бүрт хөгжлийн бэрхшээлд өртөж буй түвшин нь эрсдэл өндөртэй буюу 10-аас илүү байна.

4.3. Хөгжлийн бэршээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн зарим асуудлууд


График 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн асуудал



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зарим сэтгэл зүйн асуудлыг тодорхойлох зорилгоор сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн DASS-21 тестээр судалж үзэв. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн 79%-д нь тодорхой хэмжээгээр сэтгэл гутралын шинж байдал илэрсэн байна. Тодруулбал 12%-д нь хөнгөн түвшинд, 24%-д нь дунд түвшинд, 6% нь хүчтэй, 37%-д нь маш хүчтэй түвшинд сэтгэл гутрал илэрсэн. Тэдний 82% нь түгшүүртэй байгаагаас 2% нь хөнгөн, 17% нь дунд, 7% нь хүчтэй, 56% нь маш хүчтэй түвшинд байна. Стрессийн хувьд 29% нь хэвийн хэмжээний стресстэй байгаа бол 13% нь хөнгөн, 17% нь дунд, 24% нь хүчтэй, 20% нь маш хүчтэй түвшинд стресстэй байна.

График 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож буй сэтгэл зүйн асуудал



Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан сэтгэл зүйн асуудлуудын түвшин ялгаатай эсэхийг олон бүлгийн ялгаа үзэх статистик шинжилгээний аргаар шалгаж үзэхэд тус бүртээ статистик ач холбогдол (p<0.001) бүхий ялгаатай байна. Оюун бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлууд бусад бүлгээс илүү түвшинд тохиолдож байна. Хөгжлийн бэрхшээлийн төрөл нь сэтгэл гутралын түвшинд 4.1%-ийн, түгшүүрийн түвшинд 11.2%-ийн, стрессийн түвшинд 11.7%-ийн нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 10. Сэтгэл зүйн асуудлууд болон хүчирхийллийн хамаарал

	Эрх мэдлийн хяналт	Доромжлол буруутгал	Сэтгэл зүйн дарамт	Бие даасан байдлыг хязгаарлах	Хүчирхийлэл
Түгшүүр	0.782**	0.897**	0.879**	0.836**	0.904**
Стресс	0.812**	0.781**	0.882**	0.947**	0.911**
Сэтгэл гутрал	0.967**	0.752**	0.899**	0.850**	0.924**

Сэтгэл гутрал, стресс, түгшүүр нь хүчирхийлэл болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдтэй эерэг, хүчтэй хамааралтай байна. Хүчирхийлэлд өртсөн түвшин нэмэгдэх хэрээр сэтгэл зүйн тулгамдсан асуудлуудын түвшин түүнээс шууд хамааралтайгаар дагаад нэмэгдэж байна.

Хүснэгт 11. Хүчирхийллийн түгшүүрийн түвшинд үзүүлэх нөлөө

	R	R^2	AR	f	*p* утга	Beta
Эрх мэдлийн хяналт	0.782**	0.612	0.608	154.2	*p*<0.001	5.528
Доромжлол ба буруутгал	0.897**	0.804	0.802	401.5	*p*<0.001	6.386
Сэтгэл зүйн дарамт	0.879**	0.773	0.771	334.2	*p*<0.001	6.654
Бие даасан байдлыг хязгаарлах	0.836**	0.698	0.695	226.7	*p*<0.001	6.086
Хүчирхийлэл	0.904**	0.817	0.815	437.6	*p*<0.001	1.748

Хүчирхийлэл нь түгшүүрийн түвшинд хэрхэн нөлөөлж буйг нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар шинжилж үзэхэд эрх мэдлийн хяналт нь түгшүүрийн 61.2%-ийг түүвэрт, 60.8%-ийг эх олонлогт тайлбарлана. Эрх мэдлийн хяналт нэг нэгжээр нэмэгдэхэд түгшүүрийн түвшин 5.5 нэгжээр нэмэгдэнэ.

Доромжлол ба буруутгал нь түгшүүрийн 80.4%-ийг түүвэрт, 80.2%-ыг эх олонлогт тайлбарлана. Доромжлол ба буруутгалын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд түгшүүрийн түвшин 6.4 нэгжээр нэмэгдэнэ.

Сэтгэл зүйн дарамт нь нь түгшүүрийн 77.3%-ийг түүвэрт, 77.1%-ийг эх олонлогт тайлбарлана. Сэтгэл зүйн дарамтын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд түгшүүрийн түвшин 6.6 нэгжээр нэмэгдэнэ.

Бие даасан байдлыг хязгаарлах нь түгшүүрийн 69.8%-ийг эх олонлогт, 69.5%-ийг түүвэрт тайлбарлана. Бие даасан байдлыг хязгаарлах нь нэг нэгжээр нэмэгдэхэд түгшүүрийн түвшин 6.08 нэгжээр нэмэгдэнэ.

Хүчирхийлэл нь түгшүүрийн 81.7%-ийг эх олонлогт, 81.5%-ийг түүвэрт тайлбарлана. Хүчирхийллийн түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд түгшүүрийн түвшин 1.7 нэгжээр нэмэгдэнэ.

Хүснэгт 12. Хүчирхийллийн стрессийн түвшинд үзүүлэх нөлөө

	R	R^2	AR	f	*p* утга	Beta
Эрх мэдлийн хяналт	0.812**	0.659	0.655	189.2	*p*<0.001	5.997
Доромжлол ба буруутгал	0.781**	0.610	0.606	153.2	*p*<0.001	5.816
Сэтгэл зүйн дарамт	0.882**	0.778	0.776	344.4	*p*<0.001	6.980
Бие даасан байдлыг хязгаарлах	0.947**	0.896	0.895	847.5	*p*<0.001	7.209
Хүчирхийлэл	0.911**	0.830	0.828	477.4	*p*<0.001	1.841

Хүчирхийлэл нь стрессийн түвшинд хэрхэн нөлөөлж буйг нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар шинжилж үзэхэд эрх мэдлийн хяналт нь стрессийн 65.9%-ийг түүвэрт, 65.5%-ийг эх олонлогт тайлбарлана. Эрх мэдлийн хяналт нэг нэгжээр нэмэгдэхэд стрессийн түвшин 5.9 нэгжээр нэмэгдэнэ.

Доромжлол ба буруутгал нь стрессийн 61%-ийг түүвэрт, 60.6%-ыг эх олонлогт тайлбарлана. Доромжлол ба буруутгалын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд стрессийн түвшин 5.8 нэгжээр нэмэгдэнэ.

Сэтгэл зүйн дарамт нь нь стрессийн 77.8%-ийг түүвэрт, 77.6%-ийг эх олонлогт тайлбарлана. Сэтгэл зүйн дарамтын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд стрессийн түвшин 5.8 нэгжээр нэмэгдэнэ.

Бие даасан байдлыг хязгаарлах нь стрессийн 89.6%-ийг эх олонлогт, 89.5%-ийг түүвэрт тайлбарлана. Бие даасан байдлыг хязгаарлах нь нэг нэгжээр нэмэгдэхэд стрессийн түвшин 7.2 нэгжээр нэмэгдэнэ.

Хүчирхийлэл нь стрессийн 83%-ийг эх олонлогт, 82.8%-ийг түүвэрт тайлбарлана. Хүчирхийллийн түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд стрессийн түвшин 1.8 нэгжээр нэмэгдэнэ.

Хүснэгт 13. Хүчирхийллийн сэтгэл гутралын түвшинд үзүүлэх нөлөө

	R	R^2	AR	f	*p* утга	Beta
Эрх мэдлийн хяналт	0.967**	0.935	0.934	1408.9	*p*<0.001	7.320
Доромжлол ба буруутгал	0.752**	0.565	0.561	127.5	*p*<0.001	5.738
Сэтгэл зүйн дарамт	0.899**	0.807	0.805	410.7	*p*<0.001	7.283
Бие даасан байдлыг хязгаарлах	0.850**	0.722	0.719	254.1	*p*<0.001	6.628
Хүчирхийлэл	0.924**	0.853	0.852	570.2	*p*<0.001	1.913

Хүчирхийлэл нь сэтгэл гутралын түвшинд хэрхэн нөлөөлж буйг нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар шинжилж үзэхэд эрх мэдлийн хяналт нь сэтгэл гутралын 93.5%-ийг түүвэрт, 93.4%-ийг эх олонлогт тайлбарлана. Эрх мэдлийн хяналт нэг нэгжээр нэмэгдэхэд сэтгэл гутралын түвшин 7.3 нэгжээр нэмэгдэнэ.

Доромжлол ба буруутгал нь сэтгэл гутралын 56.5%-ийг түүвэрт, 56.1%-ыг эх олонлогт тайлбарлана. Доромжлол ба буруутгалын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд сэтгэл гутралын түвшин 5.7 нэгжээр нэмэгдэнэ.

Сэтгэл зүйн дарамт нь нь сэтгэл гутралын 80.7%-ийг түүвэрт, 80.5%-ийг эх олонлогт тайлбарлана. Сэтгэл зүйн дарамтын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд сэтгэл гутралын түвшин 7.3 нэгжээр нэмэгдэнэ.

Бие даасан байдлыг хязгаарлах нь сэтгэл гутралын 77.2%-ийг эх олонлогт, 71.9%-ийг түүвэрт тайлбарлана. Бие даасан байдлыг хязгаарлах нь нэг нэгжээр нэмэгдэхэд сэтгэл гутралын түвшин 6.6 нэгжээр нэмэгдэнэ.

Хүчирхийлэл нь сэтгэл гутралын 85.3%-ийг эх олонлогт, 85.2%-ийг түүвэрт тайлбарлана. Хүчирхийллийн түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд сэтгэл гутралын түвшин 1.9 нэгжээр нэмэгдэнэ.

ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийгөө хүчирхийлэлд өртсөнөө мэдэхгүй байх тохиолдол түгээмэл ажиглагдлаа. Боловсролын түвшин, нас, хүйс, өвчний онош үл хамааран сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг. Хоёрдугаарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд эдийн засгийн хүчирхийлэлд нийтлэг өртдөг бөгөөд энэ нь санхүүгийн хувьд хэн нэгнээс хараат байх, өөрийнх нь халамжийн мөнгийг гэр бүлийнх нь гишүүд захиран зарцуулах, сонголт хийх эрхийг нь хязгаарлах зэрэг байдлаар илэрдэг.

Мөн бэлгийн хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэлд өртсөн тохиолдлууд цөөнгүй бөгөөд эмэгтэй оролцогчид түлхүү энэ төрлийн хүчирхийлэлд өртсөнөө хуваалцаж байгаа ч боловч эрэгтэй оролцогчид ч өртсөн байна.

Хүчирхийлэл нь дийлэнх тохиолдолд гэр бүлийн орчинд үйлдэгдэж байна. Нийгмийн орчин, гудамж талбай, үйлчилгээний газар, боловсролын байгууллагад байх үед ялгаварлах, гутаан доромжлох байдлаар түлхүү илэрч сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байжээ. Орчны хүртээмжгүй байдлаас шалтгаалан нийгмийн харилцаанд оролцож чадахгүй байх, өөрт зориулагдсан зам талбай байхгүйн улмаас машин замаар явж өөрийгөө эрсдэлд оруулахын зэрэгцээ бусдад доромжлогдох нөхцөл үүсэж байгаа зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлаж буй жишээ болж байгааг мөн анхаарах шаардлагатай байна.

Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүчирхийлэлд өртсөн түвшин нь дундаж онооноос харьцангуй өндөр байна. Хүйс, гэрлэлтийн байдал зэрэг нь хүчирхийлэлд өртөх түвшинд нөлөөлдөггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нас залуу байх тусам хүчирхийлэлд өртөх байдал өндөр байдаг. Хүчирхийллийн тухай ерөнхий ойлголт сайтай, мэргэжил эзэмшсэн, хүүхэдтэй иргэд хүчирхийлэлд өртөх байдал нь бусад бүлгээс бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн ноцтой түвшинд байгаа бөгөөд хүчирхийлэлд өртөх нь эдгээр сэтгэл зүйн асуудлуудыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн хүчирхийллийн асуудал нь Монгол Улсад ноцтой бөгөөд үл анзаарагддаг хэвээр байна. Судалгааны үр дүнгээс харахад сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо өндөр, хохирогчдын дийлэнх нь эмзэг байдалд байдаг нь илэрхий байна. Энэ нь зөвхөн тухайн хүний эрүүл мэнд төдийгүй нийгмийн идэвх, амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Олон улсын жишээ болон Монгол Улсын эрх зүйн орчинд илүү оновчтой арга хэмжээ шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

1. Хууль, бодлогыг сайжруулах: Сэтгэл зүйн хүчирхийллийг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжилтийг хангах.
2. Боловсрол, сургалт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, кампанит ажлуудыг зохион байгуулах.
3. Нийгмийн хамгаалал: Хохирогчдод зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
4. Судалгаа, мониторинг: Хүчирхийллийн хэлбэр, цар хүрээг тогтмол судалж, бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх.
5. Олон улсын туршлага нутагшуулах: Швед, Канад, Япон зэрэг улсуудын сайн туршлагыг Монголд нэвтрүүлэх.

НОМ ЗҮЙ

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992).
2. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль (2016).
3. Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль (2011).
4. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (2015).
5. Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль (2018).
6. Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016).

Монгол хэлээр:

1. Батцэнгэл Г. (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс*. Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК.
2. Баярмаа, В. (2020). *Өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ*. Улаанбаатар: Би Си Ай ХХК.
3. НҮБ. (2016). *Монгол улсын хүний хөгжлийн хөгжлийн илтгэл Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол улсын хөгжилд залуучуудын оролцоо.* Улаабаатар хот.
4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. (2019). *Сэтгэл гутралын үед хийгдэх танин мэдэхүйн-зан үйлийн сэтгэл заслын техник*. Улаанбаатар: Тоонотрипт ХХК.
5. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам & Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага. (2020). *Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Асуудал: Бодлого, үйл ажиллагаа 2020*. Улаанбаатар.
6. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2021). *Хэрвээ та хүчирхийлэл, дарамтад өртсөн хэн нэгнийг мэддэг бол:.* Улаанбаатар хот.
7. Эрхэс, А. (2021). Коронавируст халдварын үед ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийг DASS-21, IES-COVID19 тестээр судалсан нь. Улаанбаатар хот: Магистрын судалгааны ажил.
8. IRIM. (2021). Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа. Улаанбаатар хот.

Англи хэлээр:

1. Barnes, C. (2012). *Understanding Disability and the Importance of Rights-Based Approaches. Disability & Society, .* 27(3), 373-386.
2. Camilleri, L. (2018 оны July 26). *Depression Anxiety Stress*. Psychology Foundation of Australia: http://www2.psy.unsw.edu.au/dass//over.htm-ээс Гаргасан

3. Council of Europe. (2006). *Council of Europe Disability Strategy 2006-2015*.
4. Government of Canada. (2019). *Accessible Canada Act*. Retrieved from Government of Canada Website.-ээс Гаргасан
5. Henry, R. (2013). *Emotional Abuse Checklist*. Rosanne Henry L.P.C: https://www.cultrecover.com/sites/default/files/pdfs/Emotional_Abuse_Checklist.pdf-ээс Гаргасан
6. International Labour Organization (ILO). (1983). C*onvention No. 159: Employment of Disabled Persons*. ILO.
7. Japan International Cooperation Agency (JICA). (2022). *Promoting Inclusion of Persons with Disabilities in Japan*. Retrieved from JICA Website.-ээс Гаргасан
8. Mikton, C. R. (2009). *Childhood violence and the risk of later life violence in developing countries: A systematic review*. The Lancet, 373(9679), 1923–1933.
9. Oliver, M. (1990). *The Politics of Disablement*. UK: Macmillan Education .
10. Oliver, M. (1996). *Understanding disability: From theory to practice*. APA PsycNet: https://doi.org/10.1007/978-1-349-24269-6-ээс Гаргасан
11. Sen, A. (1999). *Development as Freedom*. Oxford University Press.
12. Shakespeare, T. (2006). *Disability Rights and Wrongs*. Routledge.
13. Sharon Home PhD, T. A. (2008). *Disability and Emotional Abuse*. Journal of Emotional Abuse:/https://www.tandfonline.com/doi/abs/10.1300/J135v02n04_05?journalCode=wjea20-ээс Гаргасан
14. Simeonsson, R. J., et al. (2011). *Disability and the Social Model: Approaches to Disability and Human Rights*. University of California Press.
15. Swedish Institute. (2020). D*isability Policy in Sweden*. Retrieved from Swedish Institute Website.-ээс Гаргасан
16. United Nations. (1948). *Universal Declaration of Human Rights*. United Nations.
17. United Nations. (1966). I*nternational Covenant on Economic, Social and Cultural Rights (ICESCR)*. United Nations.
18. United Nations. (2006). *Convention on the Rights of Persons with Disabilities*. United Nations.
19. Waldman, M. (2014). *Psychological abuse and mental health: Global perspectives*. Oxford University Press.
20. World Health Organization. (2011). *World report on disability*. World Health Organization.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээллийн асуулга

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Код: Хүйс: Эр □ Эм □

1. Нас: ____

2. Боловсролын түвшин: _____

3. Мэргэжилтэй эсэх /Мэргэжилгүй бол эзэмшээгүй шалтгаан/

_____

4. Одоогийн хөдөлмөр эрхлэлт:

_____

5. Нийгмийн амьдралын идэвх:

_____

_____

6. Гэр бүлийн байдал:

- Ам бүл: ___
- Хэн хэнтэйгээ амьдардаг:

  _____
- Гэрлэлтийн байдал (гэрлээд хэдэн жил болсон, хүүхэдтэй эсэх, салсан шалтгаан):

  _____

  _____
- Асаргаанд байдаг эсэх /Тийм бол асаргааны нөхцөл/:

  _____

  _____
- Гэр бүлийнхэн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа эсэх /Хэн болох, хөгжлийн бэрхшээлийн төрөл/
- Гэр бүлийн хөдөлмөр эрхлэлт:

  _____

  _____

  _____

7. Өвчний оношш, шалтгаан, хугацаа:

_____

_____

8. Хүчирхийллийн талаарх ойлголттой эсэх:_____

9. Хүчирхийлэлд өртөж байсан эсэх /Тийм бол өртсөн тохиолдол/:

Хавсралт 2. ЕАС хүчирхийллийг тодорхойлох асуумж

АСУУМЖ	ХАРИУЛТ		
	Тийм	Магадгүй	Үгүй
1. Таны үзэл бодлыг байнга үгүйсгэдэг гэж та боддог уу?			
2. Таны хийсэн зүйлсийг үргэлж шүүмжилдэг үү?			
3. Таны шийдвэр гаргах эрхэд хязгаарлалт тавьдаг уу?			
4. Таныг бусадтай харилцахаас зайлсхийлгэдэг үү?			
5. Таныг бусдын өмнө доромжилж байсан уу?			
6. Таныг “чадваргүй” гэж дорд үзэж байв уу?			
7. Таныг өөртөө итгэлгүй болгох зорилготойгоор элдвээр хэлдэг үү?			
8. Таныг байнга хянаж, хязгаарлаж байсан уу?			
9. Танд айдас төрүүлэх үг хэллэг хэрэглэдэг үү?			
10. Таны санал бодлыг сонсдоггүй гэж боддог уу?			
11. Таны санхүүгийн хэрэгцээг хянаж байсан уу?			
12. Таныг гэр бүлийнхэндээ эсвэл найз нөхдөдөө очихыг хориглож байсан уу?			
13. Таныг бусдын өмнө “хэрэггүй хүн” мэт санагдуулдаг уу?			
14. Таныг өөрийгөө буруутгах байдалд хүргэдэг үү?			
15. Таны хийсэн аливаа үйлдлийг утгагүй гэж үздэг үү?			
16. Таны зан үйлийг байнга хянаж байсан уу?			
17. Таны өмнөөс бүхнийг шийддэг гэж боддог уу?			
18. Танд “энэ чиний хийх хэрэг биш” гэж ойлгуулдаг уу?			
19. Таныг ганцаардмал байдалд оруулахыг санаархаж байсан уу?			
20. Таны бодлыг өөрчлөхийн тулд дарамталж байсан уу?			

Хавсралт 3. DASS-21 (Depression Anxiety Stress Scale) буюу сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хэмжүүрийн тест

Тодорхойлолтыг уншаад өнгөрсөн хугацаанд тандтохиолдож байсан, үгүй эсэхээс хамааран 0-3 хооронд үнэлнэ үү. Зөв, буруу хариулт гэж байхгүй тул их цаг зарцуулахгүй хариулаарай.

Дараах байдлаар үнэлнэ:
0 - Надад огт тохиолдоогүй
1 - Надад заримдаа, бага хэмжээгээр тохиолдсон
2 - Надад тодорхой хэмжээгээр, тодорхой хугацаанд тохиолдсон
3 - Надад маш олон тохиолдсон, ихэвчлэн тохиолддог

1	Тайвширч чадахгүй байгаагаа олж мэдсэн	0	1	2	3
2	Ам хатахыг мэдэрсэн	0	1	2	3
3	Бүх зүйлээс ямар нэг эерэг мэдрэмж авч чадахгүй буй мэт санагдсан	0	1	2	3
4	Амьсгалахад төвөгтэй болж байсан (Ялангуяа хэт их амьсгаадах, биеийн ачаалал аваагүй байхад амьсгаадах)	0	1	2	3
5	Санаачлага гарган аливаа зүйлийг хийх, ажиллахад хэцүү байсан	0	1	2	3
6	Би нөхцөл байдалд хэт “сүртэй” хариу үзүүлэх хандлагатай байсан	0	1	2	3
7	Би салгалж чичирч байсан (жишээ нь гар)	0	1	2	3
8	Би их хэмжээний мэдрэлийн хүч зарцуулж байгаагаа мэдэрч байсан (их зүйл бодох)	0	1	2	3
9	Өөрийгөө эвгүй байдалд оруулах, сандарч самгардаж магадгүй нөхцөл байдлаас болж санаа зовж байсан	0	1	2	3
10	Надад хүсэн хүлээх зүйл юу ч байхгүй мэт мэдрэгдэж байсан	0	1	2	3
11	Өөрийнхөө хямарсан, түгшсэн байгааг мэдэрч байсан	0	1	2	3
12	Тайвшрахад хэцүү байгаагаа мэдэрч байсан	0	1	2	3
13	Би уруу царайтай, гутарсан байгаагаа мэдэрч байсан	0	1	2	3
14	Би хийж байсан юмаа дуусгахад саад болсон зүйлийг тэвчиж чаддагүй	0	1	2	3
15	Огт учраа олохгүй байх үе байсан	0	1	2	3
16	Надад ямар нэг зүйл хийх урам зориггүй үе байсан	0	1	2	3
17	Би өөрийгөө хүн шиг үнэ цэнтэй биш гэж мэдэрч байсан	0	1	2	3
18	Би хэтэрхий түргэн ууртай байсан	0	1	2	3
19	Биеийн ачаалал аваагүй боловч зүрх дэлсэхийг мэдэрч байсан	0	1	2	3
20	Ямар нэг тодорхой шалтгаангүйгээр айдас хүрэх үе байсан	0	1	2	3
21	Амьдрал утгагүй мэт мэдрэгдэх үе байсан	0	1	2	3

Судалгааны датаг цуглуулагч: Г.Энхзаяа, Б.Энхжин, Г.Амина, Б.Үжин, С.Энхцацрал, Б.Баасансүрэн, Г.Цэлмэг, Б.Амарзаяа, Б.Мөнхсувд, П.Зулаа, Б.Эрдэнэчимэг, Е.Доржпүрэв, Б.Халиун, Ж.Нандинболор, Б.Хонгорзул, Б.Мөнхгэрэл, Г.Болор, Х.Балжинням, Б.Нямжаргал, А.Анужин, М.Сарангоо, Б.Оюун-Эрдэнэ, С.Отгонболор, Б.Намнанбаяр, Б.Дэлгэрцогт, М.Азжаргал, Б.Баасансүрэн, Д.Наранхишиг.